



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/27

Хажуу шинэ-Ус

Малын сэг зэм устгал, халдваргүйтгэлийн
ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.2 дахь, 7.3.3 дахь заалт Гамшигаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх, 32.1.8 дахь, 32.1.9 дэх заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2018 оны А/52 дугаар тушаал, Аймгийн Засаг даргын 2024 оны 03 сарын 05-ны А/115 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын хэмжээнд 2023-2024 оны өвөлжилт, хаваржилт хүндэрсний улмаас хорогдсон малын сэг зэм устгалын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг нэг дүгээр хавсралтаар, ажлын төлөвлөгөөг хоёр дугаар хавсралтаар баталсугай

2.Зүй бусаар хорогдсон мал амьтны сэг зэмийг малын өвчин тархах ,байгаль орчин бохирдуулахаас сэргийлж хороо, бууц, уст цэг, бэлчээр, төв суурин газрын орчмоос цуглуулж зориулалтын цэгт булж устган халдваргүйтгэх арга хэмжээг 2024 оны 3 дугаар сарын 27-ноос 2024 оны 04 дүгээр сарын 20-ны дотор зохион байгуулж ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай

3.Зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах байгаль орчны цэвэрлэгээ халдваргүйтгэлийн ажлыг чанар үр дүнтэй зохион байгуулах удирдлагаар ханган дүн мэдээг танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч (А.Бямбадорж)-д даалгасугай

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Т.Цэрэнчунт)-д даалгасугай.

ДАРГА  ТАРИУНАА



482401037



Засаг даргын 2024 оны 03 дугаар
сарын 17 ны өдрийн АКТ тоот
захирамжийн хавсралт

Малын сэг зэм устгах ажлын хэсгийн бүрэлдэхүүн

- Ажлын хэсгийн ахлагч: Б. Даваасүрэн (Засаг даргын орлогч)
- Гишүүдэд :
- Б. Мөнхдэлгэр (1-р багийн Засаг дарга)
 - М. Амарзаяа (2-р багийн засаг дарга)
 - А.Бямбадорж (Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч)
 - Б.Мягмарсүрэн (Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч)
 - Т.Цэрэнчунт (Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)
 - Д.Сарангэрэл (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)
 - Н.Ганбат (Санхүү албаны дарга)
 - Э.Сувдмаа (Хөдөлмөр эрхлэлтийн халамжын асуудал хариуцсан мэргэжилтэн)
 - О.Баатархүү (Засаг даргын Тамгын газрын жолооч)
 - У.Сүнжидмаа (Засаг даргын Тамгын газрын нярав)